



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/495

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.27 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын лаборатори сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолт”-ын “III.Албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-ын “Туршлага” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"1.1.“Туршлага” хэсгийн “Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 10-аас доошгүй жил багшилсан байх, 5-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуульд сургалтын менежерээр болон боловсролын байгууллагад удирдах албан тушаалд ажилласан байх” гэснийг “Ерөнхий боловсролын сургуульд 6-аас доошгүй жил үндсэн орон тоонд багшилсан, 4-өөс доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн удирдах албан тушаалд эсхүл боловсролын салбарын төрийн захиргааны байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаалд ажилласан байх” гэж.

2.Энэхүү тушаалаар өөрчлөн баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг сонгон шалгаруулалт зохион байгуулахад баримтлан ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга /Л.Цэдэвсүрэн/ -д даалгасугай.

САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН

142211745



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/282

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.27 дахь заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, Бага дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Санал өгөх тухай” 502 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын лаборатори сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, ерөнхий боловсролын тусгай сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, тусгай цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2. Албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагын дагуу сонгон шалгаруулалт явуулж, дүнг танилцуулах, зохих томилгоо хийлгэх, шийдвэр гаргуулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн дарга Б.Баярсайханд даалгасугай.

САЙД



Э. БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны 05 дугаар
сарын 03-ны өдрийн А/282 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2019 оны 05 дугаар сарын 03

Байгууллагын нэр:

Ерөнхий боловсролын лаборатори сургууль

Албан тушаалын нэр:

Захирал

Ажлын цаг:

Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2-т зааснаар ажлын өдөрт 8 цаг. Шаардлагатай нөхцөлд илүү цагаар ажиллана.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮБД-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Улсын хэмжээнд 47 лаборатори сургууль. Үүнээс нийслэлд 22, орон нутагт 25 сургууль.

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бага, дунд боловсролын сургалтын агуулга, хөтөлбөр, технологи, аргазүйн хөгжлийн судалгаа, туршилтын түшиц-лаборатори сургуулийг хөгжүүлэх,

харьяалах аймаг, дүүргийн хэмжээнд багш нарын мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр сургалт-дадлагыг зохион байгуулах, бусад сургуулиудад шинэ технологи, аргазүйг түгээн дэлгэрүүлэх, зөвлөн туслах ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах.

Албан тушаалын зорилт:

1. Салбарын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын лаборатори сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.
2. Бага, дунд боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын арга зүй, технологийн судалгаа туршилтыг хэрэгжүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-дадлагыг зохион байгуулах ажлыг аймаг дүүргийн Боловсролын газартай хамтран зохион байгуулах
3. Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах
4. Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хүүхдийг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч, хүмүүжих, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Зорилго	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
Нэгдүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1.1. Бага, дунд боловсролын хууль тогтоомж, хөгжлийн бодлогыг багш, ажилтан, сурагч, эцэг, эх, асран хамгаалагчдад сурталчилан таниулах, мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг дүгнэх, тайлагнах; 1.2. Лаборатори сургуулийг хөгжүүлэх хэтийн болон дунд хугацааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; 1.3. Сургуулийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар боловсруулан баталж мөрдүүлэх; 1.4. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэр гаргах, шийдвэр гаргахад багш, ажилтан, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг мэдээлэх 	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байдал; • Хууль тогтоомж, сургуулийн хэв шинж, онцлогт нийцүүлэн сургууль хөгжүүлэх хэтийн болон дунд богино хугацааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн 	Ш, Х

Нэгдүгээр зорилтын хүрээнд.

- 1.5. Хууль тогтоомж, шийдвэр, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүн болон сургуулийн тухайн жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагад тогтоосон цаг хугацаанд багтаан тайлагнах, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх нөхцөл бүрдүүлэх;
- 1.6. Хамран сургах тойргийн сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, суурь боловсрол заавал эзэмшүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
- 1.7. Сурагчдыг сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах ажлыг холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах;
- 1.8. Суралцагчийн суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах;
- 1.9. Сургуулийн үйл ажиллагаанд удирдлага, мэдээллийн систем нэвтрүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах;
- 1.10. Боловсролын баримт бичгийг захиалах, олгох ажлыг зохион байгуулж, боловсролын мэдээллийн системд үнэн бодит байдлыг хангах;
- 1.11. Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн суралцагчийг анги дэвшүүлэх, алгасуулан суралцуулах, улируулах, сургууль төгсгөх, сургуулиас хасах, чөлөөлөх шийдвэрийг гаргах;
- 1.12. Байгууллагад өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээний тогтолцоо төлөвшүүлэх;
- 1.13. Сургуулийн үйл ажиллагааны чанар, үр дүнг тандах судалгаа, оношлогоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах;
- 1.14. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч, зохих байгууллагад шаардлага тавьж хэрэгжүүлэх;
- 1.15. Дотоод, гадаадын болон аж ахуйн нэгж, байгууллагатай хамтын ажиллагаа, түншлэл тогтоох, бэхжүүлэх, хууль тогтоомжид нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

- Сургуулийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чанарын болон тоон үзүүлэлтэд гарсан өөрчлөлт
- Баталсан эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам, хэрэгжилт, үр дүн
- Хууль, тогтоомжийн хэрэгжилтэд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

Хоёрдугаар зорилтын хүрээнд.

- 2.1. Сургуульд суурилсан менежмент, маркетинг хөгжүүлэх, сургалтын талаар баримтлах бодлого, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, багш, ажилтанд зөвлөн туслах, хамтран ажиллах;
- 2.2. Бага, дунд боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийн судалгаа, арга зүй, үнэлгээний дэвшилтэт арга, хэлбэрийг турших, инновацийг нэвтрүүлэх ажлыг боловсролын эрдэм шинжилгээ, аргазүйн байгууллага, аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага дор хэрэгжүүлж, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
- 2.3. Багшийн мэргэжил дээшлүүлэх, шинэ технологи, аргазүй эзэмшүүлэх сургалт-дадлагыг аймаг, нийслэлийн Боловсролын газартай хамтран үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг тогтвортой хэрэгжүүлэх;
- 2.4. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;
- 2.5. Бага дунд боловсролын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангах, энэ чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, эцэг, эх, олон нийтийг мэдээллээр хангах;
- 2.6. Хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, судалгаа хийх, шилдэг арга зүй, технологийг сургалтад нэвтрүүлэх ажлыг дэмжих, зөвлөн туслах;
- 2.7. Суралцагчдын онцлог, хэрэгцээ, сонирхол, сурах чадамжид үндэслэн хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хичээлээр эзэмших мэдлэг, чадвар бүтээх, хичээл хоорондын уялдаа холбоог хангах, сургалтын аргуудыг оновчтой сонгох, хэрэглэх, анги, сурагчтай ажиллах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, манлайлан оролцох, чиглүүлэх, зөвлөн туслах

- Бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнасан байдал
- Судалгаа, туршилтын үр дүнг бусад ерөнхий боловсролын сургуулиудад түгээн дэлгэрүүлэх болон зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байдал;
- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа, шинэ технологи, аргазүйг түгээн дэлгэрүүлэх сургалт-дадлагад хамрагдсан багшийн тоо
- Багш, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил, ур чадварт гарсан ахиц, өөрчлөлт

Ш,
Г,
Х

	<p>2.8. Багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл/тэнхим, багшийн ёс зүйн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны уялдааг хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, зөвлөн туслах;</p> <p>2.9. Сурлагын амжилт, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, тайлагнах.</p>	<p>Сургалтын орчин бүрдүүлэлт, ашиглалт, үр өгөөж</p>	
<p>Гуравдугаар зорилтын хүрээнд</p>	<p>3.1. Ерөнхий боловсролын лаборатори сургуулийн хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, нөөцийг зөв байршуулах;</p> <p>3.2. Багш, ажилтныг сонгон шалгаруулалтын үндсэн дээр ажилд томилж, чөлөөлөх;</p> <p>3.3. Багш, ажилтны мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;</p> <p>3.4. Багш ажилтны хөдөлмөрийн үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох эрхзүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>3.5. Багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;</p> <p>3.6. Сургуулийн бүтцийн нэгж, хэв шинж, ангийн менежментийг оновчтой тогтоох, хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлыг чанартай зохион байгуулахад сургалтын менежер, багш нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах;</p> <p>3.7. Багш нарын хичээл, сургалтын үйл явц, үр дүн, ур чадварын хөгжилд ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх, дэмжих арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх; Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчилан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологи, менежмент, маркетинг, соёлыг боловсролын технологийн үндэсний санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын алсын хараа, стратегийн зорилго зорилтонд нийцсэн хүний нөөцийн хөтөлбөр, хэрэгжилт; • Багш, ажилтны мэргэжил, ур чадварын хөгжилд гарсан ахиц, өөрчлөлт; • Байгууллагын соёл, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх арга хэмжээ, үр дүн. • Багш, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн; 	<p>Ш, Г, Х</p>

	<p>3.8. Багш, ажилтныг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчих, авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Удирдах ажилтан, багш, ажилтнууд нь ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргаагүй байх; 	
<p>Дөрөвдүгээр зорилтын хүрээнд</p>	<p>4.1. Байгууллагын төсвийн төсөөлөл, төсвийг төлөвлөх, батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг тогтоосон хугацаанд удирдан зохион байгуулах;</p> <p>4.2. Байгууллагын төсөв хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;</p> <p>4.3. Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй, цаг хугацаанд нь мэдээлэх;</p> <p>4.4. Санхүүгийн үйл ажиллагаанд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн програм хангамж нэвтрүүлэх;</p> <p>4.5. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, статистикийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь мэдээлэх, тайлагнах;</p> <p>4.6. Тухайн сургуулийн хамран сургах тойргийн хүүхдийн тоо, төлөв байдлын талаар холбогдох мэдээлэл цуглуулан, цаашдын хөгжлийн бодлогын талаархи ойрын/хэтийн төлвийн таамаглал боловсруулах;</p> <p>4.7. Бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эрүүл, аюулгүй байдал хангасан сургалтын материаллаг орчин бүрдүүлэх, сайжруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих, эрсдлийн үнэлгээ тогтмол хийх;</p> <p>4.8. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, иргэн нэвтрэх дэд бүтэц бүрдүүлэх;</p> <p>4.9. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>4.10. Суралцагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>4.11. Хүүхдийн хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын хангамж, норм, норматив, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, эрсдлээс урьдчилан сэргийлэх;</p>	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн аудитын дүгнэлт; • Сургуулийн хөрөнгө оруулалт, төсвийн ил тод байдал, төсөв, санхүүгийн үр ашигтай байдал; • Санхүү, нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээ тайланг хууль тогтоомжийн дагуу тогтоогдсон цаг хугацаанд нь үнэн зөв гаргасан байдал • Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үр дүн • Сурагчийн зөвлөлийн ажиллагаанд үзүүлсэн дэмжлэг 	<p>Ш, Г, Х</p>

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд.	<p>4.12. Сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, болзошгүй эрсдэлд өртөхөөс болон гэмт хэрэг, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>4.13. Сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, тоног төхөөрөмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар зориулалтын дагуу түрээслүүлэх;</p> <p>4.14. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн орчинд нийгэм-сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> • Орчны стандартын хэрэгжилт • Үдийн цай, дотуур байрны хоол хүнсний хангамж, норм нормативийн хэрэгжилт • Нэг угаалтуур, суултуурт ногдох хүүхдийн тоо 	Ш, Г, Х,
-------------------------------	---	---	----------------

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх
Мэргэжил	Багш, боловсрол судлал, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх
Мэргэшил	Боловсролын болон төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 10-аас доошгүй жил багшилсан байх; • 5-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуульд сургалтын менежерээр болон боловсролын байгууллагад удирдах албан тушаалд ажилласан байх;
Ур чадвар	<p>Асуудал шийдвэрлэх:</p> <ul style="list-style-type: none"> -Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй, шийдвэр гаргах; -Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох; -Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах; -Маргаан, саналын зөрүүг эв зүйгээр шийдвэрлэх <p>Манлайлах:</p> <ul style="list-style-type: none"> -Шударга ёсыг сахих; -Ёс зүйгээр үлгэрлэх; -Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх;

	<p>-Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх; -Хувийн зохион байгуулалт сайтай; -Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах</p> <p>Багаар ажиллах, удирдах: -Харилцааны ур чадвартай; -Зорилго, зорилгод нийт багш ажилтныг нэгтгэх; -Мэдээллийг багш, ажилтанд нарт тэгш хүргэх; -Албан хаагч бүрийн оролцоог жигд хангах; -Албан хаагч нарыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх;</p> <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> • Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх; • Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх; • Гадаад аль нэг хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, албан бичгээр харилцах чадвартай байх; • Заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй байх.
--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын менежер • Нийгмийн ажилтан • Багш, дотуур байрын багш • Нягтлан бодогч, нярав • Үйлчилгээний ажилтан 	<p>Бусад харилцах субъект</p> <ul style="list-style-type: none"> • Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны газар, хэлтэс • Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар • Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс • Багшийн мэргэжил дээшлүүлэх институт • Боловсролын хүрээлэн • Бусад төрийн болон төрийн бус байгууллагууд
---	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ


Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн


Байгууллагын нэр: Төрийн албаны зөвлөл

Шийдвэрийн огноо: 2019-04-29

 (Д.Наранзул)

Дугаар: 502

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД  **ЕНДОНПЭРЭНЛЭЙН БААТАРБИЛЭГ.**

/Гарын үсэг, тамга/

Байгууллагын нэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам.

Шийдвэрийн огноо: 2019-05-03

Дугаар: Тушаал А/282

2019 оны 05 дугаар сарын 03 -ны өдөр